




ЖАГСАГЧДЫГ
ХАМГААЛ

ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ УДИРДАМЖ

ТОЙМ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ





Эмнести Интернэшнл нь хүн бүр эрхээ эдэлдэг өөрчлөлтийн төлөө нэгдсэн 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн хөдөлгөөн юм.

Бидний алсын хараа бол эрх баригчид амлалтаа биелүүлж, олон улсын эрх зүйг хүндэтгэж, хариуцлага хүлээдэг ертөнц юм. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс хараат бус бөгөөд гишүүнчлэл болон хандиваар санхүүждэг.

Дэлхийн өнцөг булан бүрт хүмүүсийн хэрэгжүүлж байгаа эв нэгдэл, энэрэн нигүүлсэхүйн үйл ажиллагаа нь бидний нийгмийг илүү сайнаар өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

Хавтасны зураг:

*(Кени, Найроби) 2024 оны 7-р сарын 16.
Засгийн газрын эсрэг жагсаалын үеэр
лоозон барьсан жагсагч!*

© Sipa USA/Alamy Live News

Индекс: АСТ 30/8725/2024

Хэвлэгдсэн хэл: Англи

Эх хувь:

www.amnesty.org

© Amnesty International 2024

Өөрөөр заагаагүй бол энэ баримт бичигт агуулагдах контентыг Creative Commons (эх хувь, арилжааны бус, үүсмэл бус, олон улсын 4.0) лицензээр авсан болно.

creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудас дээрх зөвшөөрлийн хуудаснаас авна уу:

www.amnesty.org

Материалыг Эмнести Интернэшнлээс өөр зохиогчийн эрх эзэмшигчтэй холбоотой гэж үзвэл энэ материал нь Creative Commons лицензэд хамаарахгүй.

Анх 2024 онд Эмнести Интернэшнл ХХК хэвлүүлсэн

Питер Бененсоны байшин, Истон гудамж 1, Лондонгийн WC1X 0DW,
Их Британи

phrp@amnesty.nl

ТАНИЛЦУУЛГА

Тайван хуран цуглах эрхийг олон улсын эрх зүйн бүхий л томоохон баримт бичиг, гэрээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын (ХЭТТ) 20 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП)-ын 21 дүгээр зүйл, Европын Хүний эрхийн конвенцын 11 дүгээр зүйл, Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн Хартын 11 дүгээр зүйл (Африкийн Харти), Хүний эрхийн Арабын дүрэм (Арабын дүрэм)-ын 24(6), Хүний эрхийн тухай Америкийн конвенцын (ХЭАК) 15 дугаар зүйл.

ТОДОРХОЙЛОЛТ: "хуран цуглах" гэж ерөнхийдөө тодорхой зорилгоор нийтийн, хувийн болон цахим орчинд (эсвэл дотор болон гадаа, эсвэл аль алинд нь) хоёр ба түүнээс дээш хүн цугларахыг ойлгодог.

Хуран цуглах нь жагсаал, суулт гэх мэт олон янзын хэлбэр, зорилготой байх бөгөөд урт хугацаанд үргэлжилж болно. Олонх тохиолдолд хуран цуглах нь тодорхой үзэл санааг бусад хүмүүст илэрхийлэхийг эрмэлздэг хэдий ч энэ нь хуран цуглахын зайлшгүй элемент биш юм.

Уг эрхийг хэрэгжүүлсэн тохиолдолд улс орнууд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр хүндэтгэж, хангах үндсэн үүрэг хүлээдэг.

Эдгээрт дараах үүрэг хамаарна.

- Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүндэтгэх, уг эрхэд халдах аливаа үйлдлээс **татгалзах үүрэгтэй**. Иймээс эрх баригчид зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хүмүүс уг эрхийг эдлэхэд саад учруулах, боомилох, хязгаарлах ёсгүй. (хүний эрхэд суурилсан хандлага)
- Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг бусад хувь хүн, бүлгийн хөндлөнгийн оролцооноос **хамгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй**.
- Хүмүүс жагсаал, цуглаан хийх эрхээ практикт бодитоор эдлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх замаар тайван жагсаал хийх эрхээ хэрэгжүүлэхэд нь **дэмжлэг үзүүлэх үүрэгтэй**.

Улс орнууд энэ үүргийг биелүүлэхийн тулд хууль эрх зүйн болон хэрэгжих орчин нөхцөлийг бий болгож, хүмүүс тайван жагсаал, цуглаан хийх эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг бүрдүүлэх ёстой бөгөөд уг эрхийг хууль бусаар хязгаарлах аливаа арга хэмжээнээс татгалзах ёстой. Энэхүү удирдамж нь улс орнуудын дагаж мөрдөх ёстой тодорхой үүрэг, хариуцлагыг нэгтгэн дүгнэхэд чиглэсэн болно.

ТАЙЛБАР: Энэхүү удирдамж нь голчлон биет жагсаал, цуглаанд хамаарна. Гэхдээ цахим болон цахим бус аль ч орчинд уг эрх хэрэгжихдээ олон талаар огтлолцдог. Тухайлбал, жагсаал, цуглаанд бэлтгэх, зохион байгуулах эсвэл жагсаал, цуглааны үеэр болон түүний өмнө, дараа нь мэдээлэл солилцох зэрэг нь ихэвчлэн онлайн орчинд явагддаг гэх утгаараа уг эрхийг хэрэгжүүлэх чухал бүрэлдэхүүн хэмээн үздэг. Цахим орон зайд өрнөх жагсаал, цуглаанд энэхүү удирдамжийг олон тохиолдолд хэрэглэж болно.

АРГА ЗҮЙ, ХАНДЛАГА

Дэлхий дахин тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хүлээн зөвшөөрсөн хэдий ч хууль болон практикт өргөн хүрээнд энэ эрх зөрчигдсөөр ирсэн. Энэ эрхийн олон улсын хүний эрхийн зохицуулалт, хэм хэмжээг бэхжүүлэх чиглэлд олон улсын байгууллага, механизмууд хүчин чармайлт гаргасаар байна. Холбогдох эх сурвалжид олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудын ерөнхий тайлбар, НҮБ-ын дүрэмд суурилсан байгууллагуудын тайлан (НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон түүний тусгай журмын мандат эзэмшигчид орно), хүний эрхийн шүүхийн шийдвэрүүд, бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудын сэдэвчилсэн тайланг оруулсан.

Энэ удирдамжид төрийн эрх баригчид өөрийн улсын хэмжээнд тайван жагсаал, цуглаан хийх эрхийн талаар олон улсын хүний эрхийн үүргээ бүрэн хүндэтгэхийн тулд биелүүлэх ёстой хамгийн чухал үүргийг тухайлан сонгосон олон улсын баримт бичгүүдээс товчлон жагсаасан. Үүнд дараах 16 сэдвийн хүрээнд хамаарах төрийн үүрэг орсон болно.

1. Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зохицуулах эрх зүйн орчин
2. Зөвшөөрөл болон мэдэгдэл
3. Хязгаарлалт, хориглолт
4. Зохион байгуулагч, оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх
5. Хуран цуглахтай холбоотой төрийн үүрэг
6. Олон төрөлт жагсаал, цуглаан
7. Жагсаал, цуглааны үед хууль сахиулах ажиллагааг төлөвлөх, бэлтгэх
8. Хүний эрхэд суурилсан хэв журам сахиулах хандлага
9. Жагсаал, цуглаан, зохион байгуулагч, оролцогчдыг хамгаалах цагдаагийн үүрэг
10. Хэв журам сахиулахдаа ялгаварлан гадуурхахгүй байх
11. Заналхийлэл, дарамт, айлган сүрдүүлэлтээс ангид байх
12. Жагсаал, цуглааныг тараах
13. Жагсаал, цуглаанд хүч, албадлага хэрэглэх
14. Зэвсэг, тусгай хэрэгсэл
15. Жагсаал, цуглаанд мониторинг хийх
16. Цагдаагийн хариуцлага

**ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ НЬ ХҮН БҮРИЙН
ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХИЙГ АЛИВАА
ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТГҮЙГЭЭР БҮРЭН ЭДЭЛЖ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ БАТАЛГААЖУУЛАХ ЁСТОЙ.**

- 1.1 Улс орнууд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг үндсэн хууль, дотоодын хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрч, тодорхой, ойлгомжтой **эрх зүйн үндсийг бий болгох** ёстой. Тайван хуран цуглах эрх чөлөөг тансаглал болоод давуу эрх биш, харин хүний үндсэн эрх гэж үзнэ.
- 1.2 Хүн бүр ялгаварлагдахгүйгээр тайван жагсаал, цуглаан хийх эрхээ бүрэн хэрэгжүүлж, эдлэх боломжтой байх ёстой бөгөөд **эрх баригчид хүн бүрийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангах үүрэгтэй**. Төрийн эрх баригчид тайван цугларалтад оролцоход ялгаварласан хязгаарлалт тавих ёсгүй бөгөөд эрхээ бодитоор эдлэхэд саад учруулж буй ялгаварлан гадуурхалтын системчилсэн хэлбэрүүдийг идэвхтэй шийдвэрлэх шаардлагатай.
- 1.3 **Жагсаал, цуглааныг тайван замаар явагдана хэмээн үзэх ёстой**. Зохион байгуулагчид эсвэл оролцогчдын хүчирхийллийн санаа зоригийг лавтай нотлох үүргийг эрх баригчид хүлээх бөгөөд хүчирхийлэл эсвэл цөөн тооны хүний үйлдсэн бодит хүчирхийлэл нь жагсаал, цуглааныг тайван бус хэмээн үзэх үндэслэл болгохгүй. Хэдий зарим хүн хүчирхийлэл үйлдсэн боловч тайван жагсаал, цуглаанд оролцож буй бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалах, хангах нь төрийн үүрэг юм.
- 1.4. **Жагсаал, цуглаантай холбоотой төрийн үүрэг нь зөвхөн хуулийн дагуу явагдаж байгаа жагсаал, цуглаан төдийгүй, хууль зөрчсөн боловч тайван журмаар явагдаж байгаа жагсаал, цуглаанд мөн хамаарна.**

ЭРХ ЗҮЙН ОРЧИН НЬ ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ҮЙЛЧЛЭХ ЁСТОЙ

- 2.1 Хуран цугларахад **урьдчилан зөвшөөрөл авах ёсгүй**.
- 2.2. Жагсаал, цуглаан зохион байгуулах талаарх **мэдэгдлийг заавал өгөх шаардлага нь** өөрөө тайван жагсаал хийх эрх чөлөөний хязгаарлалт болох тул уг хязгаарлалтыг хуулиар тогтоох бөгөөд зайлшгүй шаардлагатай, зорилготойгоо дүйцсэн байх ёстой. Цөөн тооны оролцогчтой жагсаал, цуглаан гэх мэт ямар нэгэн онцгой бэрхшээл учруулдаггүй жагсаал, цуглаанд мэдэгдлийн шаардлага тавих ёсгүй.
- Хэрэв урьдчилан мэдэгдэх шаардлага тавихаар бол энэ нь эрх баригчдад жагсаал, цуглаанд дэмжлэг үзүүлэх үүргээ хэрэгжүүлэх, жишээлбэл, бусдын эрх, эрх чөлөө, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах, эсвэл нийтийн хэв журмыг сахиулахад бэлтгэх боломжийг бүрдүүлэх зорилготой байх ёстой. Мэдэгдлийн шаардлагыг тайван хуран цуглах эрх чөлөөг хязгаарлах хэрэгсэл болгон ашиглах ёсгүй. Мэдэгдэл өгөх шаардлагыг тодорхой нийгмийн бүлэг, тэр дундаа ЛГБТИ хүмүүсийн эрхийг хязгаарлаж, ялгаварлан гадуурхахад ашиглах ёсгүй. Мэдэгдлийн журмыг бодит зөвшөөрлийн горим болгон хувиргах байдлаар төлөвлөх, практикт хэрэгжүүлэх ёсгүй.
- 2.3 Хэрэв мэдэгдэл өгөх шаардлагыг хуульчилсан тохиолдолд урьдчилан мэдэгдэл ирүүлээгүй нь жагсаал, цуглааныг хууль бус гэж үзэх үндэслэл болохгүй. **Түүнчлэн мэдэгдэл хүргүүлээгүй нь эрх баригчдыг жагсаал, цуглааныг хамгаалах, хангах үүргээс нь чөлөөлөхгүй.**
- 2.4 Дотоодын хууль тогтоомжид аяндаа үүссэн жагсаал, цуглааныг зөвшөөрч, урьдчилан мэдэгдэх шаардлага хамаарахгүй байхаар зохицуулах шаардлагатай.

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ НЬ ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ АГУУЛГААР ОЙЛГОЖ, ХҮМҮҮС АЛИВАА АСУУДЛААР, ХЭЗЭЭ Ч, ХААНА Ч, ЯМАР Ч НӨХЦӨЛД ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ БОЛОМЖТОЙ БАЙХЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ШААРДЛАГАТАЙ

- 3.1 Зохицуулалтын тухайд **жагсаал, цуглаан зохион байгуулахад ямар нэгэн хязгаарлалт байх ёсгүй**. Эрх баригчид хязгаарлалт тавих шаардлагыг онцгой тохиолдол гэж үзэх ёстой бөгөөд ийм хязгаарлалт нь тодорхой үндэслэлтэй болохоо нотлох үүргийг төр хүлээнэ. Аливаа хязгаарлалт нь **дотоодын хууль тогтоомжид үндэслэсэн байх** бөгөөд энэ нь олон нийтэд хүртээмжтэй, хэрэгжүүлэхэд ойлгомжтой томъёолсон, урьдчилан мэдэх боломжтой байх ёстой. Аливаа хязгаарлалт нь хууль ёсны зорилгыг хангахад чиглэсэн, зайлшгүй шаардлагатай, зорилготойгоо нийцсэн, ялгаварлаагүй байх ёстой. Эдгээрийг тайван жагсаал, цуглаан хийх эрхийг дэмжих агуулгад нийцүүлэн тодорхойлох бөгөөд жагсаал, цуглаанд оролцоход саад болгон ашиглах ёсгүй. **Аливаа таамаглал нь жагсаал, цуглааныг зохион байгуулах эрх чөлөөг хангахад чиглэх ёстой**. Хуран цуглахыг хориглох нь хамгийн эцсийн арга хэмжээ байх ёстой бөгөөд өөр ямар ч арга хэмжээ нь хууль ёсны зорилгодоо хүрч чадахгүй тохиолдолд л хэрэгжүүлнэ.
- 3.2 **Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах үндэслэл болох хууль ёсны зорилгын жагсаалтыг уг эрхийг дээд түвшинд хамгаалах үүднээс улс орнууд нарийн тодорхой тайлбарлах ёстой.**
- 3.2.1. **Үндэсний аюулгүй байдлын** ашиг сонирхлын үүднээс хязгаарлалтыг зөвхөн улс орны оршин тогтнох, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг аюул заналхийлэл, хүч хэрэглэхээс хамгаалах зорилгоор тогтоох бөгөөд аюулгүй байдлын ерөнхий, тодорхой бус байдалд үндэслэж болохгүй. Тусгаар тогтнол, нутаг дэвсгэр, үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг шаардах нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул учруулахгүй бөгөөд хуран цуглахыг хориглох үндэслэл болохгүй.

- 3.2.2 Жагсаал, цуглаанд оролцогчид нь хүний амь нас, аюулгүй байдал, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах бодит болон томоохон эрсдэл бий болгож байгаа тохиолдолд л эрх баригчид **олон нийтийн аюулгүй байдлын** үндэслэлээр уг эрхэд хязгаарлалт тогтоож болно.
- 3.2.3 Зөвхөн ноцтой эмх замбараагүй байдал л **нийтийн хэв журмыг** хамгаалах зорилгоор жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах үндэслэл болно. Нийгмийн амьдралд тодорхой хэмжээний саад тотгор учруулах, тухайлбал замын хөдөлгөөний чөлөөт урсгалд саад учруулах нь тайван жагсаал цуглаан хийх эрхтэй салшгүй холбоотой тул хүлцэх ёстой бөгөөд хуран цуглахыг нь хязгаарлах, хориглох үндэслэл болохгүй. Цаашилбал, тайван жагсаал, цуглаан бусад хүмүүсийн дайсагналд өртөж магадгүй хэмээн үзэж жагсаалыг хориглох, хязгаарлахыг зөвтгөхгүй.
- 3.2.4 **Жагсаал, цуглаанд оролцоогүй бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын** тулд тайван жагсаал, цуглаанд тавих хязгаарлалтыг онцгой тохиолдолд хэрэгжүүлэх бөгөөд энэ нь зорилгод хүрэхэд шаардлагатай хамгийн бага түвшинд байх ёстой. Тайван цуглаан хийх эрх чөлөөний ач холбогдлын үүднээс олон нийт тэдний эрхэнд нөлөөлөх зарим нэг хөндлөнгийн оролцоонд хүлээцтэй хандах ёстой.
- 3.2.5 Улс орнууд зөвхөн ховор, онцгой тохиолдолд **нийтийн ёс суртахууныг** хамгаалах зорилгоор тайван хуран цуглах эрх чөлөөг хязгаарлах үндэслэлийг зөвтгөж болно.
- 3.2.6. Улс орнууд эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлсэн тохиолдолд зөвхөн нотолгоонд үндэслэн **нийгмийн эрүүл мэндийг хамгаалах** ашиг сонирхлын үүднээс хязгаарлалт тогтоож болно. Эрх баригчид хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгын үүднээс худалдааны бүс, концерт, спортын арга хэмжээ зэрэг бусад ижил төстэй цугларалтуудыг хязгаарласан тохиолдолд жагсаал, цуглаанд хязгаарлалт тавьж болно. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах нь жагсаал, цуглааныг урьдчилан хориглох үндэслэл болохгүй. Үүний оронд жагсаал, цуглаанд тогтоосон аливаа хязгаарлалт нь тухайн тохиолдол тус бүрт үндэслэх бөгөөд нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад бага хязгаарлалттай арга хэрэгсэл хангалтгүй тохиолдолд л эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх ёстой.

- 3.3. Улс орнууд тодорхой тохиолдол, цаг хугацаа, байршилд жагсаал, цуглаан зохион байгуулахыг **бүхэлд нь хориглож болохгүй**. Энэ нь тухайн нөхцөл байдалд үл нийцэх бөгөөд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчинө. Жагсаал, цуглаанд оролцогчид зорилтод бүлгийнхээ **нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц** байдлаар жагсаал, цуглааныг зохион байгуулах боломжтой байх ёстой. Жагсаал, цуглаан хийх **цаг, газар, арга хэлбэртэй** холбоотой аливаа хязгаарлалтыг тухайн тохиолдол тус бүрээр тогтоож, зайлшгүй шаардлагатай, нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцсэн байх ёстой бөгөөд ялгаварлан гадуурхсан байдлаар хэрэгжүүлж болохгүй. Цаашилбал, тодорхой жагсаал, цуглааныг хориглох нь **эцсийн арга хэмжээ байх ёстой** бөгөөд хязгаарлалт эсвэл бусад арга хэмжээ нь зорилгодоо хүрэхэд үр дүнгүй болох нь тодорхой байх тохиолдолд хэрэглэнэ. Жагсаал, цуглаан нь бусад арга хэмжээний нэгэн адил нийтийн орон зайг хууль ёсны дагуу ашиглах боломжтой байх ёстой. Нийтийн эзэмшлийн талбайг арилжааны үйл ажиллагаа, замын хөдөлгөөний урсгалыг чөлөөтэй байлгах баталгааг хангах зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглож болохгүй.
- 3.4 Хязгаарлалт, хориглолт нь **ялгаварлан гадуурхах шинж чанартай байж болохгүй** бөгөөд **төвийг сахисан байх шаардлагатай**. Жагсаал, цуглааны агуулга нь улс орнууд хориглох шаардлагатай үйлдэл болох дайныг сурталчлах, үндэсний, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлах, ялгаварлан гадуурхах, дайсагналцах, хүчирхийллийг өөгшүүлэх агуулгатай байж болохгүй. Жагсаал, цуглааны илэрхийлэхээр зорьж буй утга санаа эсвэл түүний хүрэхээр зорьж буй үр дүн нь доромжилсон, цочирдуулсан, түгшүүр төрүүлэм байсан ч энэ нь улс орнууд хязгаарлалт тавих үндэслэл болохгүй. Улс орнууд засгийн газрын эсрэг улс төрийн эсэргүүцлээ илэрхийлсэн, эрх баригчдыг эсэргүүцсэн, засгийн газар, үндсэн хууль, улс төрийн тогтолцоог өөрчлөхийг уриалсан, бие даан шийдвэр гаргахыг эрмэлзсэн тайван жагсаал, цуглааныг ил, далд хэлбэрээр хязгаарлах ёсгүй.
- 3.5. Онц байдлын үед ч **тайван жагсаал, цуглаан хийх эрхээс ухрах ёсгүй**.
- 3.6 Улс орнууд хуран цуглахыг хориглосон эсвэл жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэхийг ямар нэгэн байдлаар хязгаарласан аливаа шийдвэрийг үр дүнтэй, цаг тухайд нь, **хараат бус, шударга шүүхээр хянан шалгах баталгааг хангах ёстой**.

**УЛС ОРНУУД ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН
ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОН ОРОЛЦСОН ҮЙЛДЭЛД
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭЖ БОЛОХГҮЙ.**

- 4.1 Жагсаал цуглааны үед түгээмэл ажиглагддаг үйл ажиллагаа, тухайлбал замын хөдөлгөөнд саад учруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож болохгүй. **Олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцээгүй, дотоодын хууль тогтоомжийг зөрчсөн иргэний үл захирагдахуйн тайван үйл ажиллагаанд ямар ч хариуцлага хүлээлгэх ёсгүй.** Хэрэв тайван замаар өрнөж буй иргэний үл захирагдахуй нь олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд нийцсэн дотоодын хуулийг зөрчсөн тохиолдолд эрх баригчид иргэний үл захирагдахуйн үйлдлийн тодорхой нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой бөгөөд хэрэв хязгаарлалт, хориг арга хэмжээ авсан тохиолдолд тэдгээр нь олон улсын хүний эрхийн хуулиар зөвшөөрөгдөхүйц байх шаардлагатай. Үүний тулд хүний эрхийн хязгаарлалтад тавигдах гурван шалгуур болох хууль ёсны зорилгыг хангахад чиглэсэн байх, зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн нөхцөл байдлын хэр хэмжээнд нийцсэн байх шаардлагатай. Хэрэв эрүүгийн болон захиргааны шийтгэл оногдуулсан бол тэдгээр нь үйлдсэн зөрчилд тохирсон байх ёстой бөгөөд хорих ял шийтгэхээс зайлсхийх ёстой. Эрх баригчид тайван хуран цуглах эрх чөлөөний ач холбогдол, ард түмний дуу хоолойгоо сонсгох хэрэгцээг зохих ёсоор анхаарч үзэх шаардлагатай. Дотоодын хууль тогтоомжоор хууль бус гэж үзсэн ч тайван жагсаалд оролцох эрхийг хамгаалах бөгөөд эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх ёсгүй.
- 4.2 Жагсаал, цуглааны зохион байгуулагчид болон оролцогчид бусдын үйлдлийн төлөө хариуцлага хүлээх ёсгүй.

**ХҮМҮҮС ЧӨЛӨӨТЭЙ ХУРАН ЦУГЛАХ
ОРЧНООР ХАНГАГДАХ ЁСТОЙ.**

Тайван жагсаал, цуглааныг дэмжих нь төрийн үүрэг юм.

- 5.1 **Нийтийн хэв журам сахиулах**, аюулгүй байдлыг хангах үүргийг жагсаал, цуглааныг зохион байгуулагчид бус харин төрийн эрх баригчид хүлээх бөгөөд уг үүргийг зохион байгуулагч нарт шилжүүлэх ёсгүй.
- 5.2 **Зохион байгуулагчид жагсаал, цуглаантай холбоотой зардалд санхүүгийн хариуцлага хүлээх ёсгүй.** Эрх баригчдын зүгээс хэв журам хамгаалах, жагсаалын дараах цэвэрлэгээ хийх, эмнэлгийн тусламж үзүүлэх зэрэг холбогдох бүхий л үйлчилгээг үзүүлэх нь тайван жагсаал, цуглааныг дэмжих үүргийнх нь нэг хэсэг юм. Эрх баригчид цуглаан зохион байгуулагчдаас ийм үйлчилгээ үзүүлэхийг шаардах, мөн холбогдох зардал гаргахыг албадах ёсгүй.
- 5.3 Тодорхой бүлгүүд, тухайлбал, давхар алагчлалд өртсөн бүлгүүдийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй бүтцийн **хүчин зүйлсийг шийдвэрлэх**, эдгээр бүлэгт тулгарч болох аливаа саад бэрхшээлийг шийдвэрлэх үүрэгтэй.

АЯНДАА ҮҮССЭН, ЭСРЭГ АГУУЛГА, ЗОРИЛГОТОЙ ЖАГСААЛ ГЭХ МЭТ ОЛОН ТӨРЛИЙН ЖАГСААЛЫН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГТЭЙ

- 6.1 Нэг газар, нэг цагт зохион байгуулахаар төлөвлөж буй **аяндаа үүссэн жагсаал, цуглааныг** эрх баригчид аль нэгийг нь урьтал болгохгүйгээр боломжтой бол аль алиныг нь дэмжих үүрэгтэй. Ингэх боломжгүй тохиолдолд л эрх баригчид жагсаал, цуглааны аль алиных нь илэрхийлэхийг хүссэн санаа бодлыг үр дүнтэй хүргэх боломжит хувилбаруудыг санал болгож, шударга, ялгаварлалгүй, ил тод шийдлийг олох ёстой.
- 6.2. Бусад жагсаал, цуглааныг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн **сөрөг эсэргүүцлийн жагсаал цуглааныг** үндсэн жагсаал, цуглаантай адил байдлаар дэмжих бөгөөд, эсрэг жагсаал, цуглаанд харагдахуйц, сонсогдохуйц орчинд хийхийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ жагсаал, цуглаанд оролцогч болон эсрэг агуулга, зорилготой жагсаалд оролцогчид бие биенийхээ тайван жагсаал хийх эрх чөлөөнд саад учруулахгүй байх баталгааг эрх баригчид хангах үүрэгтэй.

**ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД ТАЙВАН ЖАГСААЛ,
ЦУГЛААНЫГ ДЭМЖИХЭД БҮРЭН БЭЛТГЭХ ЁСТОЙ.**

- 7.1 Хууль сахиулах байгууллагууд жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах ажиллагааг зохих ёсоор зохион байгуулахад чиглэсэн бодлого, дүрэм журам, гэнэтийн нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх ёстой бөгөөд эдгээрийг зөвхөн асуудал, хүчирхийллийг урьдчилан таамаглахад бус харин дэмжих үүргээ хэрэгжүүлэхээр **анхаарч боловсруулсан байх** ёстой.
- 7.2 Нийтийн жагсаал, цуглаанд зөвхөн жагсаал, цуглааныг дэмжих үүргийг хэрэгжүүлэхэд **зохих ёсоор бэлтгэгдсэн хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг** оролцуулна. Тусгай тасаг, онцгой нэгжүүдийг цуглааны эхэн үеэс ажиллуулж болохгүй бөгөөд зөвхөн ийм нөхцөл байдал үүссэн, нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд л ажиллуулна.
- 7.3 Хууль сахиулах байгууллагын бүх алба хаагчид **зохистой, зорилгод тохирсон хэрэгсэл, зэвсэгтэй** байвал зохино. Харин хүний эрхэд нийцсэн байдлаар ашиглах боломжгүй эсвэл хууль сахиулах ажиллагааны хүрээнд тохирох эсэх нь шалгагдаагүй тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, зэвсгийг огт ашиглаж болохгүй.
- 7.4 Жагсаал, цуглааны үеэр хэрэгжүүлэх цагдаагийн үйл ажиллагаанд шийдвэр гаргах, хянах, хянан шалгах удирдлагын **тодорхой гинжин хэлхээ байх ёстой** бөгөөд гаргасан шийдвэрийн хариуцлагыг хангах үүднээс тухайн шийдвэрийн дагуу хүлээх үүргийг тодорхойлсон байх шаардлагатай.
- 7.5 Жагсаал, цуглааны үед хэв журам сахиулахдаа **цэрэг, зэвсэгт хүчнээр гүйцэтгүүлэх нь тохиромжгүй байдаг**. Иймд хэв журам сахиулах зорилгоор олон нийтийн цуглааны үеэр тэднийг оролцуулахаас зайлсхийвэл зохино. Хэрэв зайлшгүй шаардлагатай бол тэднийг чиг үүргээ олон улсын хүний эрхийн эрх зүйд бүрэн нийцүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай зааварчилгаа, сургалт, зохих тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана. Мөн тэд иргэний удирдлагад захирагдаж, хийсэн үйлдлийнхээ төлөө цэргийн бус ердийн харьяаллаар хариуцлага хүлээх ёстой.

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ХАМГААЛАХ, ХАНГАХ ҮҮРГИЙГ НЭН ТЭРГҮҮНД ТАВИХ ЁСТОЙ.

Тэдний арга барил нь Мэдэх, Дэмжих, Ярилцах, Ялгах гэсэн ойлголтод тулгуурласан байх ёстой.

- 8.1 **Мэдэх:** Хууль сахиулах байгууллагууд жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүсийг ойлгохыг хичээж, хүмүүсийн эрх ашиг, зорилгод нийцүүлэн жагсаал, цуглааныг зохицуулж, үл ойлголцол, шаардлагагүй өдөөн хатгалга гаргахгүй байх шаардлагатай.
- 8.2 **Дэмжих:** Хууль сахиулах байгууллагууд хүлээцтэй хандах замаар жагсаал, цуглааныг дэмжих хандлагаар ажиллах ёстой. Хүчирхийллийн бус иргэний үл захирагдахуйн үйлдлийн эсрэг үл тэвчих арга барилаас зайлсхийх хэрэгтэй. Энэ нь шаардлагагүй хурцадмал байдлыг өдөөх, асуудлыг хурцатгах, жагсаал, цуглаанд оролцож буй хүмүүст таагүй байдал үүсгэх зэрэг сөрөг үр дагавартай.
- 8.3 **Харилцах:** Хууль сахиулах байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулагчид, оролцогчид болон бусад оролцогч талуудтай харилцахдаа харилцаа холбоо, харилцан яриаг илүүд үзэх хэрэгтэй. Зохион байгуулагчид болон оролцогчидтой харилцах нь тэднийг дэмжих зорилгын тусгал байх ёстой бөгөөд дээрээс доош эсвэл нэг талын хүч тулгасан харилцаа бус харин хоёр талын нээлттэй, ил тод яриа хэлэлцээг бий болгох замаар явагдах ёстой. Харилцаа холбоо тогтоох зохион байгуулагчид болон оролцогчдын хувьд үргэлж сайн дурын үндсэн дээр байх ёстой бөгөөд харилцаа холбоо үүсгэхээс татгалзах нь эрх баригчдын жагсаал, цуглааныг үр дүнтэй дэмжих хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтад сөргөөр нөлөөлөх ёсгүй. Цагдаагийн байгууллага аливаа асуудлын хурцадмал байдлыг намжаах, зөрчилдөөнийг тайван замаар шийдвэрлэхэд анхаарах ёстой.
- 8.4 **Ялгах:** Хууль сахиулах байгууллага нь хууль бус эсвэл хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийг ялгаж салгах ёстой. Хууль сахиулагчид жагсаал, цуглааныг бүхэлд нь нэг төрлийн бүлэг гэж үзэж болохгүй.

09

ЖАГСААЛ, ЦУГЛААН, ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ОРОЛЦОГЧДЫГ ХАМГААЛАХ ЦАГДААГИЙН ҮҮРЭГ

ЭРХ БАРИГЧИД ЖАГСААЛ, ЦУГЛААНД ОРОЛЦОГЧДЫГ ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ЭСЭРГҮҮЦЭЖ БАЙГАА ЭСХҮЛ СААД УЧРУУЛАХЫГ ЭРМЭЛЗЭЖ БАЙГАА БУСАД ХҮМҮҮСИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХАЛДЛАГААС ХАМГААЛАХ ЁСТОЙ.

Хууль сахиулах байгууллагууд нь ялгаварлан гадуурхалт, дайсагналд өртөж болзошгүй хүмүүсийн жагсаал, цуглааныг өмнө нь, жагсаалын үеэр мөн дараа нь ч хамгаалах онцгой үүрэгтэй бөгөөд энэ үүргээ ямар нэгэн ялгаварлалгүйгээр биелүүлэх ёстой.

10

ХЭВ ЖУРАМ САХИУЛАХДАА АЛАГЧЛАХГҮЙ БАЙХ

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕЭР ӨӨРИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД ҮЛ АЛАГЧЛАХ БӨГӨӨД ХЭВ ЖУРАМ САХИУЛАХДАА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН АЛИВАА ХАНДЛАГААС ЗАЙЛСХИЙХ ШААРДЛАГАТАЙ.

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЮУЛ ЗАНАЛХИЙЛЭЛ ХЭМЭЭН ҮЗЭЖ БОЛОХГҮЙ.

Тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдлэхийг хүссэн хүмүүсийг хууль сахиулагчид айлгах, заналхийлэх, хэт хөндлөнгөөс нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхээс татгалзах ёстой.

- 11.1 Хууль сахиулагчдыг байршуулах **гадаад хэлбэр нь** жагсаал, цуглаанд оролцогчдод сөрөг нөлөө үзүүлэхээргүй байхын зэрэгцээ шаардлагагүй үед хурцадмал байдлыг нэмэгдүүлэхээс зайлсхийх шаардлагатай. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын тоо нь тухайн нөхцөл байдал (оролцогчдын тоо, өмнөх хурцадмал байдлын түвшин, аюулгүй байдлын ерөнхий нөхцөл)-д тохирсон байна. Үймээнийг дарах зорилготой хуяг дуулгатай тусгай хүчнийхнийг зөвхөн нөхцөл байдал ноцтой хэмжээнд хүрсэн тохиолдолд байршуулах ёстой. Хууль сахиулах байгууллагын **алба хаагчдын нэр, хувийн дугаар нь** дүрэмт хувцас, хамгаалалтын хэрэгсэлд нь тодорхой, харагдахуйц байх ёстой.
- 11.2 Хүнийг онц ноцтой гэмт хэрэг үйлдэж байна гэсэн бодитой, үндэслэл бүхий сэжиг бий болсноос бусад тохиолдолд хууль сахиулах байгууллагын ажилтнууд цуглааны хүрээнд ямар нэгэн **саатуулах, нэгжлэг хийх** үйл ажиллагаа явуулах ёсгүй. Жагсаал, цуглааны үеэр ерөнхийд нь оролцогчдыг саатуулан зогсоох, нэгжлэг хийх (жишээ нь, энэ зорилгоор байгуулагдсан хяналтын цэгүүд дээр), түүнчлэн санамсаргүй түүврийн аргаар эсвэл тодорхой хүмүүсийг хэн гэдгээс нь хамааран ялгаварлан гадуурхаж зогсоох нь хэт гадуурхалтын шинжтэй бөгөөд жагсаал, цуглаанд оролцож байгаа хүмүүст сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ халдашгүй байдлын эрхийн зөрчил болно.
- 11.3 Хууль сахиулах байгууллага нь жагсаал, цуглаан хийх явцад **олныг хамарсан тандалтын** ил болон далд арга хэрэгсэл, **хяналтын хууль бус бусад хэлбэрийг** ашиглах ёсгүй. Жагсаал, цуглаанд оролцогчдыг бөөнөөр нь хянах нь хувийн нууцыг зөрчиж, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг эдлэхэд сөргөөр нөлөөлдөг. Ажиглалтын хэрэгслийн

аливаа хэрэглээг гэмт хэргийг илрүүлэх гэх мэт тодорхой үндэслэл, шаардлагаар хууль ёсны арга хэрэгсэл болгон ашиглаж болох боловч зорилгын хувьд олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцэхгүй гэж үзсэн арга хэрэгсэл, тухайлбал царай таних (дараах тодорхойлолтыг үзнэ үү) эсвэл өндөр түвшний тагнах программ хэрэгсэл ашиглахыг хориглоно. Биед зүүсэн камерыг байнга асаахгүй ба зөвхөн тодорхой нөхцөл байдал үүссэн үед ажиллуулна. Видео бичлэгийг нийтээр болон ялгаварлан гадуурхах тандалт хийх нүүр царай таних технологитой холбож болохгүй (1:n). Нууц цагдааг тайван жагсаалын үеэр зүгээр л тагнуулын мэдээлэл цуглуулах зорилгоор ажиллуулж болохгүй.

ТОДОРХОЙЛОЛТ: Царай таних гэдэг нь биометрийн өгөгдөлд суурилсан таних мэдээллийг цуглуулах, хадгалах, дүн шинжилгээг өргөн хүрээнд хийх, бөөнөөр нь тандах үйл явц юм. Царай таних нь хувь хүмүүсийг тандахын тулд одоо байгаа камеруудыг шинэ программ хангамж, арилжааны мэдээллийн сантай хослуулан ашигладаг. Энэхүү программ хангамжийг олон нийтийн сүлжээ, жолооны үнэмлэхийн бүртгэл болон бусад мэдээллийн сангаас авсан сая сая зургийг ашиглан компаниуд бүтээдэг бөгөөд ингэхдээ хүмүүст урьдчилан мэдэгдэж, зөвшөөрлийг нь авдаггүй. Эдгээр хэрэгсэл нь ихэвчлэн CCTV камерын сүлжээтэй хослуулсан тохиолдолд өдрийн аль ч цагт хотын аль хэсэгт байгаагаас үл хамааран хувь хүмүүсийг таньж, тандах боломж олгодог. 1:n гэдэг нь таних зорилгоор тухайн хүний зургийг олон зураг агуулсан өргөн мэдээллийн сангаас (жишээ нь паспорт шалгах үед тухайн хүний зургийг 1:1 харьцаатай иргэний үнэмлэхтэй нь тааруулахаас ялгаатай) ашигладаг болохыг хэлнэ.

- 11.4 **Дур зоргоор баривчлахыг ямар ч үед хориглох** бөгөөд хууль сахиулагчид шүүхийн хяналтгүйгээр эсвэл хувь хүний оролцоо, хууль бус үйлдэл гаргасан эсэхийг үл харгалзан хүмүүсийг хоморголон баривчлахыг хориглоно. **Хэдийгээр дур зоргоор биш хэдий ч хүнийг баривчлах нь тэдний жагсаал, цуглаанд оролцох эрхэд нь саад учруулдаг тул үүнийг зайлшгүй тохиолдолд л хийх ёстой.** Тухайлбал, иргэний үл захирагдахуйн хүчирхийллийн бус үйлдлийг жагсаал, цуглааны үеэр биш харин дараа нь шийдвэрлэх боломжтой. Зохицуулалтын хувьд хэнийг ч жагсаал, цуглаанд

оролцоход нь саад учруулах зорилгоор урьдчилан саатуулах ёсгүй. Аливаа баривчилгаа нь хүний эрхэд нийцсэн, шүүхийн үндсэн баталгааг бүрэн хүндэтгэсэн байдлаар явагдах ёстой.

- 11.5 Жагсаал, цуглааныг бүхэлд нь тараахаас зайлсхийхийн тулд хүчирхийлэл үйлдэгч цөөн хүнийг саатуулах онцгой арга хэмжээ болох «хоморголон бөөндөх” гэсэн цагдаагийн тактикаас зайлсхийх ёстой. Энэ нь зөвхөн богино хугацаанд явагдах ёстой бөгөөд хүчирхийлэл үйлдээгүй хүмүүс жагсаал, цуглаанд цаашид хэвийн оролцох, эмнэлгийн тусламж авах, ариун цэврийн байгууламж ашиглах, цаг агаарын таагүй нөхцөл байдал зэрэг аливаа аюулаас хамгаалагдах шаардлагатай.

12 **ЖАГСААЛ ЦУГЛААНЫГ ТАРААХ**

ЭРХ БАРИГЧИД ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ТАРААХЫГ ЭЦСИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛНЭ

Жагсаал, цуглаан тараах үйлдлийг зайлшгүй шаардлагатай үед буюу бусад бүх арга зам хууль ёсны зорилгодоо хүрч чадаагүй тохиолдолд л хийж болно. Эрх баригчид тайван жагсаал, цуглааныг тарааж болохгүй гэсэн дүрэм бий.

Нийтийн эзэмшлийн зам талбайг хааж, замын хөдөлгөөнд саад учруулсан хүчирхийллийн бус иргэний үл захирагдахуйн үйлдлийг дан ганц бусдад саад учруулсан гэх үндэслэлээр тарааж эсвэл хориглож болохгүй. Хүчирхийлэл үйлдэгдсэн үед цагдаа нар юуны өмнө цуглааныг бүхэлд нь тараахын оронд хүчирхийлэл үйлдэгч этгээдэд анхаарлаа хандуулж, хүчирхийлэл тархахаас урьдчилан сэргийлэх ёстой. Оролцогчдод цагдаагийн хүч хэрэглэхгүйгээр сайн дураараа тарах боломжийг олгох ёстой.

**ХҮЧ, АЛБАДЛАГА ХЭРЭГЛЭХ НЬ
ЭЦСИЙН АРГА ХЭМЖЭЭ БАЙХ ЁСТОЙ.**

- 13.1 **Хүч хэрэглэх аливаа үйлдэл нь хууль ёсны зорилгыг хангахад чиглэсэн, зайлшгүй, пропорциональ буюу тухайн нөхцөл байдалд тохирсон, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцсэн байх ёстой.** Мөн эрх баригчид хүч хэрэглэх шаардлагаас зайлсхийх, хүч хэрэглэсэн тохиолдолд хохирлыг багасгах боломжит бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах ёстой.
- 13.2 **Тайван жагсагчдын эсрэг** хэзээ ч **хүч хэрэглэж болохгүй.** Шийтгэлийн зорилгоор хүч хэрэглэхийг ямар ч үед хориглоно.
- 13.3 Цагдаа юуны өмнө **хүчирхийллийн бус арга** хэрэглэж, нөхцөл байдлыг намжаахыг оролдох ёстой. Хэрэв хүч хэрэглэхээс зайлсхийх боломжгүй бол хүч хэрэглэх талаар хүмүүст урьдчилан анхааруулах ёстой.
- 13.4 Цагдаа хүч хэрэглэхдээ зөвхөн **хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийг онилох** ёстой.
- 13.5 Хүч хэрэглэсэн тохиолдолд тайлагнах ёстой бөгөөд гэмтэж бэртсэн, хохирсон хэн бүхэнд **эмнэлгийн тусламж үзүүлэх** шаардлагатай.

**АЛИВАА ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ТОХИОЛДОЛД ХУУЛЬ САХИУЛАГЧИД
ХОХИРОЛ БОЛОН ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ЭРСДЭЛИЙГ
ХАМГИЙН БАГА БАЙЛГАЖ, ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕЭР
ХҮЧ ХЭРЭГЛЭСНИЙ УЛМААС УЧИРЧ БОЛОХ БАЙСАН
ХОХИРЛООС ИЛҮҮ ИХ ХОХИРОЛ УЧРУУЛАХ ЁСГҮЙ.**

- 14.1 Хууль сахиулах байгууллагууд учирч болзошгүй янз бүрийн нөхцөлд хариу арга хэмжээ авахын тулд цагдаагийн бие бүрэлдэхүүнийг олон төрлийн үхлийн аюул багатай тусгай хэрэгсэл, зэвсгээр хангах шаардлагатай. Тэд тухайн зэвсгийг ашиглахтай холбоотой хор хөнөөлийн зэрэгтэй уялдуулан (тухайн зэвсгийг ашиглахтай холбоотой урьдчилан тооцоогүй эрсдэл зэрэг) зэвсэг тус бүрт **холбогдох тодорхой, нийтэд хүртээмжтэй дүрэм, журамтай байх шаардлагатай. Зэвсгийг зөвхөн хүчирхийллийн үед хэрэглэх бөгөөд харин тайван жагсагчдын эсрэг эсвэл аливаа тушаалыг идэвхгүй байдлаар эсэргүүцэж байгаа хүмүүсийн эсрэг хэзээ ч хэрэглэж болохгүй. Аливаа зэвсгийг хэрэглэхийн өмнө анхааруулга өгч, тушаалыг биелүүлэх хангалттай хугацаа өгөх ёстой.**
- 14.2 Цохих зэвсэг буюу **"бороохой"**-г зөвхөн **хүчирхийлэл үйлдэж буй хүмүүст чиглэсэн хариу арга хэмжээ** авах эсвэл хүчирхийллийн бодит аюул заналхийллийн эсрэг ашиглана. Хэрэглэх зорилго нь тухайн хүнийг хүндээр гэмтээхгүйн тулд өвдөлтөөр дамжуулан хүчирхийллийн үйлдлийг зогсооход чиглэнэ. Цагдаа нар хүмүүсийг элдэн хөөж, дайралдсан хүн бүрийг бороохойгоор цохих буюу «бороохойн шийтгэл» нь хууль бусаар хүч хэрэглэх үйлдэл бөгөөд үүнийг хориглох ёстой.
- 14.3 **Кинетик цохилтын хуванцар болон резинэн сумыг (KIPs)** зөвхөн **бусад хүмүүсийн эсрэг ноцтой хүчирхийлэл үйлдэж, ноцтой гэмтэл, хүний амь насанд халдах эрсдэлтэй үйлдэл хийж байгаа хүмүүсийн эсрэг** ганцаарчилсан хариу арга хэмжээ авах хэрэгсэл болгон ашиглаж болно. Уг зэвсгийг хэрэглэх зорилго нь тухайн хүнийг

хүндээр гэмтээхгүйн тулд өвдөлтөөр дамжуулан хүчирхийллийн үйлдлийг зогсооход чиглэнэ. Цагдаагийн алба хаагч хэзээ ч хүч хэрэглэсэн үйлдэл хийгээгүй олон хүн рүү буудаж болохгүй бөгөөд нүд гэх мэт эмзэг эрхтэнг гэмтээхгүйн тулд биеийн доод хэсэгт чиглүүлэх ёстой.

- 14.4 Химийн цочроох бодис, тухайлбал **"нулимс асгаруулагчийг"** зөвхөн хүчирхийлэл үйлдэгч этгээдийг онилох замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй болтол **хүчирхийлэл өргөн тархсан тохиолдолд** л хэрэглэж болно. Жагсаал цуглааны үеэр ойрхон тусдаа хүчирхийллийн үйлдэл гарсан нь нулимс асгаруулагч хий ашиглахыг зөвтгөх үндэслэл болохгүй. Учир нь ойрхон эсхүл дэргэд нь байгаа тайван жагсагчдад нэгэн адил сөргөөр нөлөөлнө. Тайван жагсаал, цуглааныг тараахын тулд нулимс асгаруулагч хий ашиглахыг хориглох шаардлагатай. Үүнийг хэрэглэх зорилго нь хүмүүсийг тараахад чиглэх бөгөөд харин үүнийг хүмүүс тарах боломжгүй хаалттай буюу хашигдмал газарт хэзээ ч ашиглаж болохгүй. Нулимс асгаруулагч хийгээр хүмүүс рүү шууд буудаж огт болохгүй. Зөвхөн сайтар шалгасан, зөвшөөрөгдсөн химийн цочроогчийг хэзээ, хэрхэн хэрэглэх талаар тодорхой, ойлгомжтой зааварчилгааны дагуу хэрэглэнэ.
- 14.5 Бага оврын, голдуу гартаа барьж хэрэглэх химийн цочроох бодис болох **"нулимс асгаруулагч шүршигч"**-ийг зөвхөн **өөрийгөө болон бусад хүнд** гэмтэл учруулах аюул заналхийлж буй хүмүүсээс **хамгаалах** зорилгоор ашиглаж болно. Үүнийг ашиглах зорилго нь тухайн хүнийг хүндээр гэмтээхгүй байхын тулд өвдөлтөөр дамжуулан хүчирхийллийн үйлдлийг нь зогсооход чиглэнэ.
- 14.6 Өндөр даралтат усан буу буюу **усан хөөргийг** зөвхөн хүчирхийлэл үйлдэгч этгээдийг онилох замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй болтол **хүчирхийлэл өргөн тархсан тохиолдолд** л хэрэглэж болно. Ийм нөхцөлд усан хөөргийг ашиглах нь **зөвхөн жагсаал, цуглааныг тараах тушаалыг хэрэгжүүлэх зорилгод** чиглэх учиртай. Тусгаарлагдсан хүчирхийллийн үйлдэл нь усан хөөрөг хэрэглэсэн үйлдлийг зөвтгөх үндэслэл болохгүй. Учир нь энэ нь ойр орчмын хүмүүс болон тайван жагсагчдад нөлөөлөх өндөр эрсдэлтэй байдаг. Өндөр даралтын горимд цагдаа хэзээ ч хүмүүсийг ойрын зайнаас онилох эсвэл хүмүүсийн толгой, нүүр рүү шууд чиглүүлэх ёсгүй. Усан хөөрөгийг хэзээ ч хөдөлгөөн нь хязгаарлагдсан эсвэл хөдөлж чадахгүй байгаа хүмүүс рүү чиглүүлж болохгүй.

- 14.7 Нийтийг хамарсан жагсаал, цуглааны үеэр ажиллаж буй хууль сахиулагчид **цахилгаан гүйдлээр цохигч** (PESW буюу “Тазер” гэж нэрлэдэг)-оор тоноглогдсон байж болохгүй. Эдгээр нь **нийгмийн хэв журмын нөхцөл байдалд тохиромжгүй** бөгөөд ноцтой аюул заналхийлж буй хүн рүү тодорхой чиглүүлэхэд хүндрэлтэй төдийгүй хүчирхийллийг даамжруулах эрсдэл өндөртэй байдаг.
- 14.8 **Морьдыг** зөвхөн **ложистикийн зорилгоор** маш болгоомжтой (жишээ нь илүү өндрөөс харах, хууль сахиулахад хялбар байлгах эсвэл бие махбодийн бэрхшээлээс үүдсэн нөхцөлд) ашиглах ёстой бөгөөд ингэхдээ зэвсэг болгон ашиглаж болохгүй
- 14.9 **Нохойг олон нийтийн цугларалтад зэвсэг болгон ашиглаж болохгүй.**
- 14.10 **Галт зэвсэг** нь жагсаал, цуглааныг зохицуулах тактикийн хэрэгсэл биш. Үүнийг зөвхөн **бусад хүний амь насанд аюул учруулах бодитой аюулын эсрэг** эцсийн арга хэрэгсэл болгон хэрэглэх бөгөөд ойр орчим байгаа бусад хүмүүст эрсдэлгүй нөхцөлд л хэрэглэнэ. Тодорхой хүн рүү чиглүүлэхгүйгээр нийт олон руу буудахыг ямар ч үед хориглоно. Ямар ч тохиолдолд жагсаал, цуглааны үеэр хууль сахиулахдаа **автомат галт** зэвсэг хэрэглэж болохгүй.

СЭТГҮҮЛЧ БОЛОН АЖИГЛАГЧ ЗЭРЭГ ЖАГСААЛ, ЦУГЛААНД МОНИТОРИНГ ХИЙЖ БАЙГАА БУСАД ХҮНИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ ТАЛААРХ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

Мониторинг хийж байгаа хүмүүс жагсаал, цуглаанд саадгүй нэвтрэх боломжтой байх хийгээд жагсаал, цуглааныг хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр баримтжуулах боломжтой байх ёстой.

- 15.1 Эрх баригчид жагсаал, цуглаан болохоос **өмнө, жагсаал цуглааны үеэр болон дараа нь хүн бүр мэдээлэл авах, солилцох боломжтой байх** баталгааг хангах ёстой. Энэ нь жагсаал, цуглааны чухал элемент бөгөөд жагсаал, цуглааны нэгэн адил хамгаалагдсан байх ёстой. Эрх баригчид жагсаал, цуглааны хариу арга хэмжээ болгон интернэтийн сүлжээг таслах ёсгүй бөгөөд жагсаал, цуглааны ажиглалтад дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Албан ёсны эрх авсан сэтгүүлчид төдийгүй **хүн бүр цуглааныг хөндлөнгөөс ажиглах, мониторинг хийх, сурвалжлах эрхтэй**. Жагсаал, цуглаан нь хууль ёсны, хууль бус, тайван, тайван бус эсэхээс үл хамааран ажиглагчдад жагсаал, цуглаан болж буй газарт саадгүй нэвтрэх боломжийг олгох, хөндлөнгийн нөлөөгүйгээр мониторинг хийх боломжтой байх ёстой. Үүнд жагсаал, цуглааны үеэр видео бичлэг хийх, гэрэл зураг авах, ялангуяа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын үйлдлийг бичлэг хийж баталгаажуулах эрх багтсан. Холбогдох тоног төхөөрөмжийг хураах, гэмтээж, устгахыг хориглоно.
- 15.2 **Жагсаал, цуглааныг тараах нь мониторинг хийх эрхийг дуусгавар болгохгүй** бөгөөд жагсаал, цуглааныг тарааж байгаа нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд мониторинг хийхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулах үндэслэл болохгүй.
- 15.3 **Сэтгүүлч, мониторинг хийж байгаа хүмүүс болон бусад ажиглагч халдлага, хүчирхийллээс хамгаалагдсан байх ёстой**.

ЭРХ БАРИГЧИД ЖАГСААЛ, ЦУГЛААНД ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГААД ЗОХИХ ХЯНАЛТ ТАВИХ, УЧИРЧ БОЛОХ АЛИВАА ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛД БҮРЭН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ БАТАЛГААГ ХАНГАХ ЁСТОЙ

- 16.1 Улс орнууд жагсаал, цуглааны туршид цагдаагийн үйл ажиллагаа хууль ёсны эсэхийг үнэлэх **хяналтын урьдчилсан механизмтай** байх ёстой. Цагдаа нар хүч хэрэглэсэн, цуглааны үеэр хүн гэмтэж бэртсэн, хохирсон, хүчирхийлэл гарсан бүхий л тохиолдолд зохих мөрдөн байцаалт явуулах ёстой. Үүнд **цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ерөнхий арга барил, холбогдох бодлого, зааварчилгааг** хамруулсан байх ёстой бөгөөд сургамжаас үр дүнтэй суралцахад чиглэх ёстой. Хууль сахиулагчид дүрэмт хувцас, эмх замбараагүй байдлын үед хэрэглэх хэрэгсэл дээрээ өөрийн нэрийн пайз, таних дугаар зэргийг илт харагдахуйц байршуулах ёстой бөгөөд энэ нь хувь хүнийг тодорхойлох, хариуцлага хүлээлгэх боломжийг олгоно.
- 16.2 Жагсаал, цуглааны үеэр явуулсан цагдаагийн үйл ажиллагааны улмаас иргэний эрх зөрчигдсөн тохиолдолд шүүхээр хянан шалгуулах баталгааг улс улсууд бүрдүүлэх ёстой. Хүний эрхийн зөрчил үйлдсэн хууль сахиулагчдад сахилгын эсвэл эрүүгийн шийтгэл ногдуулах, хохирлыг нөхөн сэргээх, эрх зөрчигдөхөөс өмнөх байдалд сэргээх зэргээр **хүний эрхийн зөрчилд бүрэн хариуцлага хүлээлгэх ёстой**. Хууль зүйн хариуцлагыг зөвхөн хууль сахиулах үүрэг гүйцэтгэсэн албан хаагч төдийгүй хууль бус тушаал өгсөн, эсвэл өөрийн хяналт, удирдлага дор байгаа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүний эрхийн зөрчлийг таслан зогсоож, урьдчилан сэргийлж чадаагүй, түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөлтөд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүй аливаа захирагч, ахлах албан тушаалтнуудад хүлээлгэх шаардлагатай.



A vigil in Brussels, featuring pictures of the disappeared, to express solidarity with the Saturday Mothers, ahead of their 1000th vigil. Saturday Mothers/People are relatives of victims of enforced disappearances, who have been prevented from organizing peaceful assemblies in Istanbul's Galatasaray Square, a place of symbolic importance to the group.

© Amnesty International



«ЦАГДАА БА ХҮНИЙ ЭРХ» ХӨТӨЛБӨР

Нидерландын Эмнести Интернэшнлийн “Цагдаа ба Хүний эрх” хөтөлбөр нь Эмнести Интернэшнл хөдөлгөөний хүрээнд цагдаа болон хэв журам сахиулахтай холбоотой асуудлыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд цагдаа, цагдаагийн байгууллагын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой. Бид өөрсдийн үйл ажиллагаа, энэхүү удирдамж зэрэг хэвлэн гаргасан бусад материалаараа дамжуулан хүний эрхийн хууль, хэм хэмжээг хэв журам сахиулахад хэрэгжүүлэх боломжтой бөгөөд зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулахыг эрмэлздэг.

Та илүү ихийг мэдмээр байна уу?

- Манай цахим хуудсаар зочилоорой www.amnesty.mn
- Эмнести академийн Цагдаа ба хүний эрхийн хичээлийг судлаарай
- Цагдаа ба Хүний эрхийн мэдээллийн сангаас холбогдох бүх нийтлэлийг олж уншаарай
- Бидэнтэй холбогдох цахим хаяг: phrp@amnesty.nl



«ЖАГСАГЧДЫГ ХАМГААЛ» ЭМНЕСТИГИЙН КАМПАНИТ АЖИЛ

Эмнести Интернэшнл “Жагсагчдыг хамгаал” кампанит ажлаараа дамжуулан тайван замаар хуран цуглах, жагсах эрх зөрчигдөж байгааг илчилж, эерэг өөрчлөлтийн төлөөх дэлхий даяарх хөдөлгөөнүүдийг дэмжихээр ажиллаж байна. Бидний зорилго бол бүх хүнд тайван замаар үйл ажиллагаа явуулах, жагсаал цуглаан хийх эрхээ аюулгүй, сөрөг үр дагаваргүйгээр хэрэгжүүлэх боломжийг олгох явдал бөгөөд тайван жагсаалын эсрэг халдлагыг эсэргүүцэж, зорилтод бүлгүүдтэй эв санааны нэгдэлтэй байж, хүний эрхийн өөрчлөлтийн төлөө тэмцэж буй нийгмийн хөдөлгөөнүүдийг дэмжих явдал юм.

Энэхүү кампанит ажил нь засгийн газруудад хандан жагсагчдыг хамгаалж, тайван хуран цугларахад тулгарч буй саад тотгор, шаардлагагүй хязгаарлалтыг зогсоохыг уриалж байгаа билээ.

ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ УДИРДАМЖ

Тайван жагсаал цуглаан хийх эрх нь нийгмийн хамгийн хүчирхэг хөдөлгөөнүүдийн хөдөлгөгч хүч болж, шударга бус байдал, хүчирхийллийг илчилж, хариуцлага нэхэж, хүмүүсийг илүү сайхан ирээдүйд итгэх итгэлийг зоригжуулдаг.

Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг бүрэн эдлэх нь хүндэтгэж, хамгаалах ёстой хүний бусад эрх, тухайлбал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, хувийн нууцтай байх, амьд явах, чөлөөтэй байх, аюулгүй байх, дүр мэдэн баривчлах, цагдан хорих, аливаа ялгаварлан гадуурхалт, эрүү шүүлт, бусад зүй бус харьцах, шийтгэлээс ангид байх эрхтэй салшгүй холбоотой.

Харамсалтай нь эдгээр амин чухал эрхүүд халдлагад өртсөөр байна. Засгийн газар болон эрх мэдэл бүхий бусад хүмүүс эсэргүүцлийн хөдөлгөөнийг нүхчин дарах, шүүмжлэлт дуу хоолойг боомилох шинэ арга замуудыг байнга эрэлхийлсээр байна. Цагдааг цэрэгжүүлж, жагсаал цуглаан хийх үед цагдаагийн хүч хэрэглэх нь нэмэгдэж, иргэний орон зайг хумиж буй дэлхий даяарх чиг хандлага нь дуу хоолойгоо хүргэх, аюулгүй байдлаа хангахад улам бүр хэцүү болгож байна.

Олон улсын хүний эрхийг хангах механизм, байгууллагууд эдгээр эрхэд хамаарах хүний эрхийн хэм хэмжээг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал гэрээ хэлэлцээрт хяналт тавих байгууллагуудын ерөнхий тайлбар, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон Тусгай илтгэгчид, тусгай мандат бүхий НҮБ-ын дүрэмд суурилсан байгууллагуудын тайлан, хүний эрхийн шүүхийн шийдвэр, хүний эрхийн бүс нутгийн байгууллагуудын сэдэвчилсэн тайлан зэргийг нэрлэж болно.

Эмнести Интернэшнлээс гаргасан энэ удирдамж нь улс орнуудын дагаж мөрдөх ёстой тодорхой үүрэг, хариуцлагыг нэгтгэн товч танилцуулсан болно.

Индекс: АСТ 30/8725/2024

2024 оны 11 дүгээр сар

[amnesty.org](https://www.amnesty.org)

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ 